| Дубна дахь Цөмийн шинжилгээний институт | 128.100,00 | Үе шаттайгаар | 60.000,00 | 68.100,00 | |
| Цөмийн туршилтыг хоригло х Гэрээний байгууллага | 5.630,00 | Нэг удаагийнхаар | 5.630,00 | | |
| Химийн зэвсгийн хоригло х байгууллага | 17.200,00 | Нэг удаагийнхаар | 17.200,00 | | |
| Далайн ёроолын маргааныг шийдвэрлэх олон улсын шүүх | 3.600,00 | Нэг удаагийнхаар | 3.600,00 | | |
| Далайн тээврийн олон улсын байгууллага | 7.000,00 | Нэг удаагийнхаар | 7.000,00 | | |
| Ази, Африкийн хуулийн зөвлөлдөх хороо | 32.150,00 | Нэг удаагийнхаар | 32.150,00 | | |
| НҮБ-ын Орчны хөтөлбөр | 12.000,00 | Нэг удаагийнхаар | 12.000,00 | | |
| Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэртэй тэмцэх хороо | 1.753,00 | Нэг удаагийнхаар | 1.753,00 | | |
| БҮГД ДҮН | 949.620,00 | | 399.333,00 | 323.100,00 | 227.187,00 |

ТАЙЛБАР: Олон улсын эдгээр байгууллагад 1999, 2000, 2001 төлөх татварыг энд оруулаагүй болно.

Засгийн газрын 1998 оны 173 д
гаар тогтоолын 2 дугаар хавсра

ГИШҮҮНИЙ ТАТВАР, ХАНДИВЫГ НЬ УЛСЫН
НЭГДСЭН ТӨСВӨӨС ТӨЛӨХ ОЛОН УЛСЫН
БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

1.Нэгдсэн Үндэстний Байгууллага
2.НҮБ-ын Энхийг сахиулах хүчин
3.НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
4.НҮБ-ын Хүүхдийн сан
5.НҮБ-ын Хүн амын сан
6.НҮБ-ын Орчны хөтөлбөр
7.НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёл байгууллага
8.Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
9.Дэлхийн цаг уурын байгууллага
10.НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
11.Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сан
12.НҮБ-ын Үйлдвэр, хөгжлийн байгууллага
13.Дэлхийн худалдааны байгууллага
14.Олон улсын валютын сан
15.Дэлхийн банк
16.Азийн хөгжлийн банк
17.Олон улсын хөдөлмөрийн байгууллага
18.Азийн хөдөлмөрийн бүтээмжийн байгууллага
19.Олон улсын атомын энергийн агентлаг
20.Дубна дахь Цөмийн шинжилгээний нэгдс институт
21.Олон улсын эрүүгийн цагдаагийн байгуулла ИНТЕРПОЛ
22.Дэлхийн гаалийн байгууллага
23.Олон улсын статистикийн институт
24.Ази, Номхон далайн бүсийн статистикі институт
25.Хавдар судлалын олон улсын төв
26.Мал, амьтны халдварт өвчний эсрэг тэмі олон улсын байгууллага
27.Цөмийн туршилтыг бүрэн хориглох ту: Гэрээний байгууллага
28.Химийн зэвсгийг хориглох байгууллага
29.Далайн ёроолын маргааныг шийдвэрлэх о улсын шүүх
30.Далайн тээврийн олон улсын байгууллага

31.Хянан шалгах дээд байгууллагуудын олон ...ын холбоо
32.Хянан шалгах дээд байгууллагуудын Азийн ...лбоо
33.Олон улсын парламентын холбоо
34.Ази, Номхон далайн орнуудын парламентуудын ...ын санчдын ассоциаци
35.Парламентуудын ерөнхий нарийн бичгийн дарга...ын ассоциаци
36.Олон улсын номын сангийн нийгэмлэг, ...гууллагуудын холбоо
37.Байгалийн гамшгийн аюулыг бууруулах Азийн ...ийн төв
38.Биологийн төрөл зүйлийг хамгаалах тухай ...венц
39.Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон ...лийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенц
40.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Конвенц
41.Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг ...ар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны ...ай Конвенц
42.Ган, цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын Конвенц
43.Дэлхийн өвийн хороо
44.Олон улсын театрын байгууллага
45.Дэлхийн жуулчны байгууллага
46.Олон улсын үзэсгэлэнгийн товчоо

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

...998 оны 9 дүгээр ...арын 16-ны өдөр Дугаар 175 Улаанбаатар хот

### Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай

...онгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:
... "Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны ...теги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн ...лбөр"-ийг хавсралтын ёсоор зөвшөөрсүгэй.

2. Гадаад харилцааны яамны зохион байгуулалт
бүтцийг дор дурдсанаар баталсугай:
а/ Бодлого төлөвлөлт, зохицуулалтын газар;
б/ Гадаад худалдаа, хамтын ажиллагааны газар;
в/ Төрийн захиргааны удирдлагын газар;
г/ Ёсолын хэлтэс;
д/ Улс төрийн газар;
е/ Олон улсын байгууллагын газар;
ж/ Эрх зүйн газар;
з/ Мэдээлэл, мониторингийн газар.

3. Гадаад бодлого, олон улсын харилцааны асуудла судалгаа хийх, хэвлэн нийтлэх үүрэг бүхий судалгаа төвийг Гадаад харилцааны яамны дэргэд байгуулах зүйтэй гэж үзсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зар яамдын бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1996 о 8 дугаар сарын 7-ны өдрийн 182 дугаар тогтоолын дүгээр зүйлийн "а" заалтыг хүчингүй болсо тооцсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

**Гадаад харилцааны сайдын үүрэг гүйцэтгэгч** **Р.АМАРЖАРГАЛ**

Засгийн газрын 1998 оны 1
дугаар тогтоолын хавсра

## ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

### 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1.1. Оршил

Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны стратег бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид "Хөтөлбө гэх)-т Гадаад харилцааны сайдын болон Засгийн газр Танхимын шийдвэрийг боловсруулан гаргаж, хэрэгжү лэхэд дараах чиглэлээр дэмжлэг үзүүлэх ү ажиллагааны стратеги, бүтцийн загварыг тодорхойлов:

- **стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах;**
- **төрийн захиргааны удирдлагаар хангах;**
- **зохицуулалтаар хангах;**
- **бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийж, үр дүнд нь үнэлгээ өгөх;**

**..2. Үндэслэл**

:өтөлбөрийг дараахь бичиг баримтыг үндэслэн овсруулав:

- Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн *"Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"*-ны баримт бичиг;
- Засгийн газрын 1996 оны 205 дугаар тогтоолоор зөвшөөрсөн *"Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"*;
- Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн *"Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт шинэчлэл"* бүрэлдэхүүн хэсгийн МОН/94/102 төслийн хүрээнд боловсруулсан *"Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн ерөнхий загвар"* төслийн тайлан.

**.3. Хууль тогтоомжийн орчин**

Хөтөлбөрийг Монгол Улсын дор дурдсан хууль гоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- **Үндсэн хууль;**
- **Засгийн газрын тухай хууль;**
- **Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;**
- **Төрийн албаны тухай хууль;**
- **Олон улсын гэрээний тухай хууль;**
- **Бусад хууль тогтоомж.**

**.4. Арга зүй**

өтөлбөрийг боловсруулахдаа дараахь арга зүй болон ı улсын шилдэг туршлагыг хэрэглэв:

- өөрчлөлтийн удирдлагын арга зүй;
- үйл ажиллагаа (бизнес)-ны төлөвлөлт бо дахин инженерчлэлийн арга зүй;
- байгууллагын өөрчлөлтийн арга зүй.

### 1.5. Удирдлагын ерөнхий чиг үүргийн яамны үүрэг хариуцлагын хуваарь

Гадаад харилцааны яам нь Засгийн газрын удирдла ерөнхий чиг үүргийн яамны хувьд дараахь үү хариуцлага хүлээнэ:

- Засгийн газрын үйл ажиллагааны стратег хэрэгжүүлэх, Гадаад харилцааны сайд болон Засг газрын Тамгын бүх талын зөвлөлгөө, дэмж үзүүлэх;
- гадаад бодлого, нэгдсэн төлөвлөлт бо бодлого, төсвийн зарцуулалтын тэнцвэр, харил уялдаа холбоог хангах асуудалд Засгийн газар, яа өндөрлөгөөс өргөн хүрээтэй хандах, зөв зохис удирдах;
- Засгийн газрын гадаад харилцааны зөвлөх үүрэг хариуцлагыг хүлээх.

## 1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Гадаад харилцааны яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр:




Гадаад харилцааны яамны үндсэн үйлчлүүлэгч буюу эзэмшигч нь Гадаад харилцааны сайд, Засгийн газрын танхим байна.

Гадаад харилцааны яамны стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон төрлийн нарийн түвэгтэй харилцааг зохицуулахад оршино.

Гадаад харилцааны яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, хэмжээ, хэлбэрийг тус яамнаас хэрэгцээний эх үүсвэр бүрээр тогтоон яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

## 2. ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГ

### 2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны стратеги мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүл чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбө Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Гада харилцааны сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх оршино.

### 2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Гадаад харилцааны яам нь доор дурдсан ү ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

- ⇒ **Монгол Улсын аюулгүй байдлын таат гадаад орчин бүрдүүлэх;**
- ⇒ **Монгол Улсын үндэсний хөгжилд таат гадаад орчин бүрдүүлэх;**
- ⇒ **Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх;**
- ⇒ **Иргэдийн эрх ашгийг хилийн чанад баталгаатай хангах.**

### 2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

***Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны эрхэм зорилго***

*Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд олон улсын таатай гадаад орчин бүрдүүлэх*

### 2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Гадаад харилцааны яам нь эрхэм зорилгынхоо хүрэ доор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилт хэрэгжүүлнэ:

**1. Гадаад бодлогын стратегийн төлөвлөлт, бодло удирдамжаар хангах;**

**2. Төрийн захиргааны удирдлагын манлайлл хангах;**

**3. Гадаад бодлогын хэрэгжилтийг зохицуулах;**

**4. Гадаад бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжил (мониторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх.**

### 2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Гадаад харилцааны яам нь стратегийн зорилт тус рийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл иллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

*1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын рээнд:*

*1.1. Гадаад бодлогын стратегийн төлөвлөлт, длогын удирдамжаар хангах;*

*1.2. Үндэсний хөгжилд гадаад таатай орчин рдүүлэх бодлого боловсруулах.*

*2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын рээнд:*

*2.1. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг нгах;*

*2.2. Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах;*

*2.3. Ёслолын үйлчилгээ үзүүлэх.*

*3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын рээнд:*

*3.1. Хоёр талын харилцааны бодлогын хэрэгжилтийг хицуулах;*

*3.2. Олон талын хамтын ажиллагааны бодлогын рэгжилтийг зохицуулах;*

*3.3. Эрх зүйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах.*

*4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын рээнд:*

*4.1. Гадаад бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ онииторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх;*

*4.2. Мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллээр үйлчлэх.*

### 2.6. Үйл ажиллагааны зорилт

Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны гол зорилт с бүрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны рилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

### 2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Гадаад харилцааны яамны үйл ажиллагаа **(бизнес)-ны** ратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

## ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА (БИЗНЕС)-НЫ СТРАТЕГИЙН ЗАГВАР



## 3.ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦОО, БҮТЭЦ

### 3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоонд дараахь зарчмыг баримтлав:

1. *Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим;*

2. *Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим* (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх);

3. *Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим* (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал, яамны бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

4. *Бүтцийн хувьд энгийн байх зарчим* (тухайн яамны Төрийн нарийн бичгийн даргаас хамгийн доод нэгжээ хүртэл аль болох цөөн буюу гурваас дээшгүй шат дамжлагатай байх);

5. *Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим* (тухайн яамны үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар, удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх);

6. *Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим* (тухайн яамны төрийн захиргааны албан хаагч нь тухайн сайд, Засгийн газар (Танхим), бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн

аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх);

*7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим* (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, бүтэц нь чадавхиа бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

### *3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар*

Дээр дурдсан зарчим болон Гадаад харилцааны яамны үйл ажиллагаа **(бизнес)**-ны стратегийн загварыг үндэслэн тус яам нь дор дурдсан үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоотой байна:

**ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР**



### *3.3. Гадаад харилцааны яамны бүтэц*

Гадаад харилцааны яамны үйл ажиллагаа **(бизнес)**-ны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус яам доор дурдсан бүтэцтэй байна:




### *3.4. Бүтцийн нэгж, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүрэг*

**1. Гадаад бодлогын стратегийн төлөвлөлт, бодлогын дирдамжаар хангах асуудал эрхэлсэн бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр орилтын хүрээнд Гадаад харилцааны сайдын эрхлэх

асуудлын хүрээний стратегийн бодлого, төлөвлөгөө
хөтөлбөр боловсруулах үндсэн үүргийг хүлээж, гадаа
бодлогын урт, дунд, богино хугацааны стратегий
төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, үндэсни
хөгжлийн гадаад таатай орчныг бүрдүүлэх зэрэг чи
үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Гадаад харилцаа
сайд, Засгийн газрын Танхимын үйл ажиллагааны ү
нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ. Энэ нь Гадаа
харилцааны сайд, Засгийн газрын Танхимын стратегий
төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсо
шийдвэр гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгий
газрын гишүүн, Гадаад харилцааны сайдыг шаардлагата
мэдээлэл, өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурха
зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр ханга
замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэг
нь Гадаад харилцааны сайд, Засгийн газрын Танхим бай
бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч н
бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэг
агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуй
нэгж болон хэвлэл, мэдээлэл, төрийн бус байгууллага
ард иргэд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох го
түнш нь бусад яам байна.

**2. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэ**
**бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаа
зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын боло
хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах үндсэ
үүргийг хүлээж, яамны үйл ажиллагаанд удирдлагы
шилдэг тэргүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх
хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлы
шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцо
тогтолцоог хөгжүүлэх, ёслолын үйлчилгээ үзүүлэх зэр
үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварла
төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшс
албаны хүчээр яамны тасралтгүй, хэвийн, жи
ажиллагааг хангахад чиглэнэ. Энэ нь Гадаад харилцаа
сайдад болон яамны аппаратад шийдвэр боловсруула
гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилг
үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөлгөө, дэмжлэгэ
хангах, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэ
тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төри

ахиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний йл ажиллагаа, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэх, жиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар эрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч ь Гадаад харилцааны сайд, яамны Төрийн нарийн ичгийн дарга, нэгжүүд, төрийн захиргааны албан аагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг эрэглэгч нь гадаадад суугаа дипломат болон консулын өлөөлөгчийн газар, бусад хэрэглэгч байна. Энэ йлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, асгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны лбаны зөвлөл, боловсрол, сургалтын болон эрдэм инжилгээний байгууллага байна.

**3. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал рхэлсэн бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар орилтын хүрээнд гадаад бодлогын хэрэгжилтийг охицуулах үндсэн үүрэг хүлээж, хоёр талын харилцаа олон олон талын хамтын ажиллагааны бодлого, өтөлбөр, төслийн хэрэгжилт, тэрчлэн эрх зүйн одлогын хэрэгжилтийг зохицуулах, консулын харилцааг охицуулах, гадаад паспорт, виз олгохтой холбогдсон йлчилгээ үзүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг эрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Засгийн газар, Гадаад арилцааны сайдын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, одлого, төсвийн тэнцвэрт байдал, харилцан уялдаа олбоог хангахад чиглэнэ. Энэ нь төсөв, санхүүгийн элон бусад нөөцийг оновчтой хуваарилах замаар одлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгуул-агатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажилла-аг бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд иглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар эрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч ь Гадаад харилцааны сайд, Засгийн газрын холбогдох охируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, дипломат болон онсулын төлөөлөгчийн газар байх бөгөөд шууд бус элбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь төсвийн айгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, эгэд, манай улсад суугаа гадаадын дипломат болон онсулын төлөөлөгчийн газар, гадаад орон, олон улсын

байгууллага, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээ үзүүлэхэд оролцох гол түнш нь бусад яам байна.

**4. Мэдээлэл, хяналт-шинжилгээ (мониторинг), үнэлгээний асуудал эрхэлсэн бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд гадаад бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (**мониторинг**) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх үндсэн үүргийг хүлээж, гадаад харилцааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явц байдалд хяналт-шинжилгээ (**мониторинг**) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллээр хангах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ. Энэ н бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, ү дагаврыг ажиглах замаар яамны бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцо байгаа бүх байгууллага, удирдах, гүйцэтгэх алба тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэ зөвлөлгөө, дэмжлэгээр цаг тухайд хангах замаа хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэг нь Гадаад харилцааны сайд, Төрийн нарийн бичгий дарга, яамны нэгжүүд, бусад яам, Засгийн газры холбогдох агентлаг, гадаадад суугаа дипломат боло консулын төлөөлөгчийн газар байх бөгөөд шууд бу хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь төрий холбогдох байгууллага, бусад хэрэглэгч байна. Эн үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгий газрын Хэрэг эрхлэх газар, хэвлэл, мэдээлэл, эрдэ шинжилгээний байгууллага байна.

---ooOoo---

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1998 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр | Дугаар 176 | Улаанбаатар хот

### Нэмэгдсэн өртгийн албан татварт хамруулах тухай

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 үгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэх
орилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр бараа,
үтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх,
йлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй нэмэгдсэн
ртгийн албан татвар ногдох борлуулалтын жилийн
рлого нь 15 сая төгрөгөөс дээш өмчийн бүх төрөлд
амаарагдах аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг 1998
ны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдсэн
ртгийн албан татварт хамруулсугай.

2.Үйл ажиллагааны онцлогийг харгалзан аялал,
уулчлал эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагыг 2000
ны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдсэн
ртгийн албан татварт хамруулсугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Худалдааны
лбан татварын тухай" Засгийн газрын 1992 оны 12
угаар сарын 31-ний өдрийн 87 дугаар тогтоол, "Монгол
лсын 1994 оны төсвийн гүйцэтгэлийг хангах талаар
вах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1994
ны 6 дугаар сарын 27-ны өдрийн 119 дүгээр тогтоолын
4 дэх заалт, "Худалдааны албан татвар ногдуулах,
элөх, тайлагнах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах
ухай" 1995 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 72 дугаар
огтоол, "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 1997
ны 5 дугаар сарын 28-ны өдрийн 127 дугаар тогтоолыг
ус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч — Ц.ЭЛБЭГДОРЖ

Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч — Б.БАТБАЯР

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1998 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Дугаар 177 Улаанбаатар хот

**Зарим тогтоол, тогтоолын заалт хүчингүй болсонд тооцох тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:
Худалдааны албан татварын хууль хүчингүй болсонтой холбогдуулан хавсралтад дурдсан Засгийн газрын тогтоол, тогтоолын заалтыг хүчингүй болсон тооцсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

**Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч** **Б.БАТБАЯР**

Засгийн газрын 1998 оны 17 дугаар тогтоолын хавсрал

## ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ЗАРИМ ТОГТООЛ, ТОГТООЛЫН ЗААЛТЫН ЖАГСААЛТ

1."Худалдааны албан татвараас чөлөөлөх тухай 1993 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 1 дүгээр тогтоо
2."Худалдааны албан татвараас чөлөөлөх тухай 1993 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 36 дугаар тогтоо
3."Импортын зарим нэрийн барааны гаалийн албан татварын хувь хэмжээг хөнгөлөх, зарим түүхий эд материалыг худалдааны албан татвараас чөлөөлөх тухай 1994 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 16 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл
4."Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 1994 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 177 дугаар тогтоолын 2 дугаар зүйл.
5."Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах худалдааны албан татвар ногдуулж байх тухай" 19 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 7 дугаар тогтоол.

6."Худалдааны албан татвар болон гаалийн татварын тухай" 1996 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоол.

7."Булчин задрах гоц халдварт өвчинтэй тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 1996 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 255 дугаар тогтоолын 5 дугаар зүйл.

8."Худалдааны албан татвараас чөлөөлөх тухай" 1997 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 206 дугаар тогтоол.

9."Худалдааны албан татвараас чөлөөлөх тухай" 1997 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 207 дугаар тогтоол.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1998 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Дугаар 179 Улаанбаатар хот

### Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Усны аж ахуйг бие даасан салбар болгон өргөжүүлсний 60 жилийн ойг 1998 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр тэмдэглэхийг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч Н.Алтанхуягт зөвшөөрсүгэй.

2.Ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг улс, орон нутгийн төсвөөс хөрөнгө гаргахгүйгээр зохион байгуулахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч Н.Алтанхуяг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч Ц.ЭЛБЭГДОРЖ

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч Н.АЛТАНХУЯГ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1998 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр | Дугаар 181 | Улаанбаатар хот

**Дүрэм, журам батлах тухай**

Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлий 4, 17 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт заасныг үндэсл Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллагь дүрэм"-ийг 1 дүгээр, "Эрүүл мэндийн магадлан итгэмж лэх байгууллагын шинжээч сонгон шалгаруулах журам"-ь 2 дугаар, "Эмнэлгийн мэргэжилтэн эмчлэх, сувилах, т барих үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунга журам"-ыг 3 дугаар, "Эрүүл мэндийн байгууллага магадлан итгэмжлэл олгох, сунгах журам"-ыг 4 дүгэ хавсралтын ёсоор тус тус батлсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч** — **Ц.ЭЛБЭГДОРЖ**

**Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын үүрэг гүйцэтгэгч** — **Ш.БАТБАЯР**

Засгийн газрын 1998 оны 181 дү гээр тогтоолын 1 дүгээр хавсра

### ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ

**Нэг.Нийтлэг зүйл**

1.Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллага ү ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, энэх дүрмийг баримтална.

2.Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгуулла (цаашид "магадлан итгэмжлэх байгууллага" гэх) нь ү ажиллагааныхаа орлогоор санхүүжиж, бие даан ажилл ашгийн төлөө бус улсын байгууллага байна.

3.Эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжл (цаашид "итгэмжлэл" гэх), эмнэлгийн мэргэжилтэ

мчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа явуулах өвшөөрөл (цаашид "зөвшөөрөл" гэх) олгох үүргийг рүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв айгууллагаас зөвшөөрөл авсан эрүүл мэндийн магадлан тгэмжлэх байгууллага гүйцэтгэнэ.

4.Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллага нь лсын хэмжээнд нэг байна.

**Хоёр. Магадлан итгэмжлэх байгууллагын зорилго**

5.Магадлан итгэмжлэх байгууллагын зорилго нь эрүүл эндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, ехнологи, стандартын мөрдөлтөд шинжилгээ хийж, мнэлгийн мэргэжилтэнд эмчлэх, сувилах, эм барих үйл жиллагаа явуулах зөвшөөрөл олгох, энэ талаар дүгнэлт аргаж магадлан итгэмжлэхэд оршино.

**Гурав.Магадлан итгэмжлэх байгууллагын бүтэц**

6.Магадлан итгэмжлэх байгууллага нь энэ дүрмийн 5-заасан зорилгыг хэрэгжүүлэх чадвар бүхий зохион айгуулалтын бүтэцтэй байна.

7.Магадлан итгэмжлэх байгууллагын дэргэд Магадлан тгэмжлэх зөвлөл ажиллана.

8.Уг зөвлөл нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн эрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн янагтын алба, анагаах ухааны сургалтын байгууллага, эргэжлийн нийгэмлэг, магадлан итгэмжлэх байгууллагын элөөлөл бүхий 9-11 хүний бүрэлдэхүүнтэй байна. агадлан итгэмжлэх зөвлөлийн ажиллах журам болон үүний бүрэлдэхүүнийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн эрийн захиргааны төв байгууллага батална.

9.Магадлан итгэмжлэх зөвлөл нь итгэмжлэл, зөвшөө-эл олгох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хяналт авих, уг үйл ажиллагаатай холбогдон гарах санал, омдлыг хянаж шийдвэрлэх үндсэн чиг үүрэгтэй киллана.

10.Магадлан итгэмжлэх байгууллага нь итгэмжлэл, өвшөөрөл олгох чиг үүргийг хэрэгжүүлэх орон тооны элон орон тооны бус магадлан шинжлэх шинжээчтэй айна.

11.Магадлан итгэмжлэх байгууллага нь орон нутагт элбартай байж болно. Түүний бүрэлдэхүүнийг Магадлан

итгэмжлэх зөвлөлийн санал болгосноор тухайн аймгий Засаг даргын шийдвэрээр батална.

## Дөрөв. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа

12.Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь эрүү мэндийн тусламж, үйлчилгээнд жигд шаардлага, стандар хэрэглэх, бусдын нөлөөнд үл автах, шударга шийдвэ гаргаж байх зарчимд тулгуурлана.

13.Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь нээлттэй ил тод байж, магадлан итгэмжлэлийн дүнг нийтэ мэдээлж байна.

14.Итгэмжлэл, зөвшөөрөл авахаар хүсэлт гаргаса эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэн в Магадлан итгэмжлэх байгууллагад үйлчилгээний хөл төлнө. Үйлчилгээний зардлыг тооцох журмыг эрүү мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны тө байгууллага тогтооно.

15.Итгэмжлэл, зөвшөөрөл олгох үйл ажиллагаа тухайн байгууллага, хүмүүсийн хүсэлтийг үндэслэн саі дүрмын үндсэн дээр явуулна.

16.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргаа ны төв байгууллага, орон нутгийн Засаг даргын Тамга газар шаардлагатай гэж үзвэл эрүүл мэндийн байгуул лага, эмнэлгийн мэргэжилтний талаар дүгнэлт гаргуула санаачилга гаргаж болно.

## Тав. Магадлан итгэмжлэх байгууллагын үүрэг, эрх

17.Магадлан итгэмжлэх байгууллага нь дор дурдса үүрэгтэй:

а/эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжл олгох, сунгах;

б/эмнэлгийн мэргэжилтэнд эмчлэх, сувилах, эм бар үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах;

в/эрүүл мэндийн байгууллагын түвшинг тодорхойл дүгнэлт гаргах;

г/итгэмжлэл, зөвшөөрөл авсан байгууллага, эмнэл гийн мэргэжилтний бүртгэл, мэдээллийн санг бі болгож, ажиллуулах;

д/орон нутгийн салбарыг мэргэжил, арга зүі удирдлагаар хангах;

е/магадлан итгэмжлэл авсан байгууллагуудад эмнэл-
ий тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх
хэлбэр хэрэгжүүлэхэд аргачлал, заавраар хангах;
ж/эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилт-
 итгэмжлэл, зөвшөөрлийн асуудлаар лавлагаа өгөх,
ал, дүгнэлт гаргах;
з/итгэмжлэл, зөвшөөрөлтэй холбогдсон санал, гомд-
 хүлээж авч, шийдвэрлэх.
18.Магадлан итгэмжлэх байгууллага нь дор дурдсан
 эдэлнэ:
а/эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилт-
с итгэмжлэл, зөвшөөрөл авахаар хүсэлт гаргаж
үлсэн шаардлага хангаагүй материалыг буцаах;
б/итгэмжлэл, зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан
үл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэн нь
элгийн тусламж, үйлчилгээний технологи, стандартын
рдлага болон мэдлэг, чадварын зохих түвшинг
гаагүй нөхцөлд итгэмжлэл, зөвшөөрөл олгохгүй байх;
в/итгэмжлэл, зөвшөөрөл олгох ажиллагааг боловс-
гүй болгох талаар санал боловсруулж, холбогдох
гууллагад тавих;
г/итгэмжлэл, зөвшөөрөлтэй холбогдох гэрчилгээ,
млэх, хаягийн загвар, бүртгэл судалгааны маягтыг
лан мөрдүүлэх;
д/эрхэлсэн асуудлаараа гадаад орон, олон улсын
гууллагатай харилцаж, тогтсон журмын дагуу гэрээ,
элцээр байгуулах, мэдээлэл солилцох;
е/магадлан итгэмжлэх байгууллагын шинжээчдийг
гон шалгаруулж ажиллуулах;
ж/итгэмжлэл, зөвшөөрлийг хууль тогтоомж, журмын
уу хүчингүй болгох.

### Зургаа. Магадлан итгэмжлэх байгууллагад тавих шаардлага

9.Магадлан итгэмжлэх байгууллага нь дараахь
рдлагыг хангасан байна:
/магадлан итгэмжлэх байгууллагын удирдлага болон
гэжлийн шийдвэр гаргах албан тушаалтан нь
алаврын зэрэгтэй эмч, эм зүйч, менежер, хуульч,
йн засагч болон бусад шаардлагатай мэргэжил
эшсэн байх;
/дээрх албан тушаалтан нь эрүүл мэндийн тусламж,
илгээний технологи, стандартад шинжилгээ хийх,

эрүүл мэндийн байгууллагын түвшинг тодорхойлох эмнэлгийн мэргэжилтний мэдлэг чадварыг үнэлж дүгнэх энэ талаар судалгаа явуулж, дүгнэлт гаргах чадвартай мэргэшсэн, туршлагатай байх;

в/үйл ажиллагаа явуулах ажлын байр, шалгалт авах мэдээллийн сан ажиллуулах, судалгаа хийх, хэвлэл олшруулах болон бусад шаардлагатай техник хэрэгслээ хангагдсан байх;

г/холбогдох ном зүй, хууль эрхийн лавлагаа /номы сан/-тай байх.

Засгийн газрын 1998 оны 181 ду
гээр тогтоолын 2 дугаар хавсрал

### ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

1.Магадлан итгэмжлэх байгууллагаас шинжээч сонго шалгаруулах тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээ зарлана.

2.Шинжээч нь мэргэжлээрээ 8-аас доошгүй жи ажилласан, дадлага туршлагатай, мэргэшсэн, ёс зүй зөрчилгүй иргэн байна.

3.Шинжээчээр ажиллахыг хүсэгч нь дараахь материа лыг бүрдүүлж бүртгүүлнэ:

а/өргөдөл;

б/биеийн байцаалт;

в/иргэний үнэмлэх;

г/боловсролын диплом, мэргэжлийн үнэмлэхи хуулбар;

д/мэргэжлийн нийгэмлэгийн санал;

е/ёс зүйн хорооны дүгнэлт;

ж/байгууллагын тодорхойлолт.

4.Магадлан итгэмжлэх байгууллага нь шинжээчэ томилох эсэх тухай хариуг 21 хоногийн дотс шийдвэрлэнэ.

5.Магадлан итгэмжлэх байгууллага нь шинжээчэ ажиллах хүсэлт гаргасан хүмүүсийг мэргэжлийн бэлтгэ дадлага туршлага, мэдлэг чадвараар нь сонго шалгаруулж, шинжээчийн эрх олгоно.

6.Шинжээч нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээн технологи, стандартын мөрдөлт, эмнэлгийн мэргэжилтн мэдлэг, чадварын түвшинд үнэлгээ өгөх үүрэг хүлээнэ,

7.Шинжээчийн эрхийг 2 жилийн хугацаатай олгож, Магадлан итгэмжлэх байгууллагаас үнэмлэх олгоно.

Засгийн газрын 1998 оны 181 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

**ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭНД ЭМЧЛЭХ, СУВИЛАХ, ЭМ БАРИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.Эмнэлгийн мэргэжилтэнд эмчлэх, сувилах, эм барих йл ажиллагаа явуулах зөвшөөрөл (цаашид "зөвшөөрөл" эх) олгох, түүний хугацааг сунгах, зөвшөөрлийг үчингүй болгох үйл ажиллагааг Эрүүл мэндийн тухай ууль, энэхүү журам болон бусад холбогдох хууль ортоомжоор зохицуулна.

2.Энэхүү журам Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүн мчлэх, сувилах, эм барих мэргэжлийн үйл ажиллагаа вуулах эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгоход ргэний харьяалал, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр амаарна.

**Хоёр. Эмчлэх, сувилах, эм барих зөвшөөрөл олгох**

3.Зөвшөөрлийг эмчлэх, сувилах, эм барих мэргэжлийн йл ажиллагаа явуулахыг хүссэн эмнэлгийн мэргэжилтэнд лгоно.

4.Зөвшөөрөл олгох мэргэжил, нарийн мэргэшлийн агсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн ахиргааны төв байгууллага батална.

5.Зөвшөөрлийг Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх айгууллага мэргэжлийн болон нарийн мэргэшлийн алгалт (цаашид "шалгалт" гэх) авсны үндсэн дээр лгоно.

6.Шалгалтыг олон сонголттой сорилоор авах ба алгалтын ерөнхий агуулгыг эрүүл мэндийн асуудал рхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

7.Шалгалт авах журмыг Эрүүл мэндийн магадлан тгэмжлэх байгууллага батална.

8.Олон сонголттой сорилыг эрүүл мэндийн асуудал рхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан гуулга дотор Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх

байгууллага нь мэргэжлийн нийгэмлэг, сургалтын байгууллагатай хамтран боловсруулна.

9.Шалгалт авах журам, шалгалтын агуулга, олон сонголттой сорилтой холбогдсон асуудлаар гарын авлагыг Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллагаас урьдчилан хэвлэж гаргана.

10.Эмнэлгийн мэргэжилтэн зөвшөөрөл авахаар хүсэлт гаргахдаа дараахь материалыг бүрдүүлнэ:

а/өргөдөл;

б/иргэний үнэмлэхийн хуулбар;

в/боловсролын диплом, мэргэжлийн үнэмлэхийн батлагдсан хуулбар;

г/биеийн байцаалт /батлагдсан маягтаар/;

д/4х6 хэмжээтэй зураг 2 хувь;

е/ажил олгогчийн санал, тодорхойлолт;

ж/мэргэжлийн нийгэмлэгийн тодорхойлолт.

11.Эмнэлгийн мэргэжилтэн материалаа бүрдүүлж эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллагын орон нутгийн салбарт өгнө.

12.Орон нутгийн салбар нь материалыг зохих шаардлага хангасан гэж үзвэл Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллагад шалгалт авах өдрөөс 2 сарын өмнө хүргүүлнэ.

13.Анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий сургууль болон төгсөлтийн дараахь нарийн мэргэшил олгох сургалт төгсөгчдийн материалыг сургалт явуулсан байгууллага бүрдүүлж Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллагад ирүүлнэ.

14.Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллага нь зөвшөөрөл авах хүсэлт гаргасан хүмүүст шалгалтанд орох зөвшөөрлийг, хэрэв татгалзсан бол үндэслэлээ орон нутгийн салбар, сургалтын байгууллагад 1 сарын дотор мэдэгдэнэ.

15.Шалгалтыг аймаг, нийслэлд тодорхой цагт нэгэн зэрэг авах бөгөөд шалгалт авах хугацааг 6 сарын өмнө товлон зарлана.

16.Шалгалтын дүнг үндэслэн зөвшөөрөл олгох, эсэх тухай шийдвэрийг шалгалт авч дууссанаас хойш нэг сарын дотор Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллагаас гаргана.

17.Зөвшөөрөл олгосныг баталгаажуулан гэрчилгээ олгоно.

18.Зөвшөөрөл олгох шалгалтад тэнцээгүй эмнэлгийн мэргэжилтэн сургалтад хамрагдсаны дараа дахин шалгалт өгөх эрхтэй.

## Гурав.Зөвшөөрлийн хугацааг сунгах

19.Зөвшөөрлийг 5 жил тутамд сунгана. Зөвшөөрлийг тасралтгүй сургалтын кредит биелүүлсэн нөхцөлд сунгана.

20.Мэргэжил дээшлүүлэх сургалтын кредитийг зөвшөөрөл авсан тухайн мэргэжлийн дагуу төлөвлөгөө, хөтөлбөрийг нь эрх бүхий байгууллагын зүгээс баталсан мэргэжил дээшлүүлэх сургалт, семинарт оролцох, ном, эрдэм шинжилгээний бүтээл туурвих хэлбэрээр биелүүлнэ.

21.Гадаад оронд мэргэжил дээшлүүлэх сургалтад оролцсон тохиолдолд кредитийг дотоодын сургалттай адилтган тооцно.

22.Тасралтгүй сургалтын кредитийг тооцох журмыг Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллагаас батлан гаргана.

23.Эмнэлгийн мэргэжилтэн нь кредитийн биелэлтийг жрон нутгийн салбарт жил тутам бүртгүүлнэ.

24.Зөвшөөрөл сунгахад дараахь материалыг бүрдүүлнэ:

а/мэргэжил дээшлүүлэх тасралтгүй сургалтын кредит биелүүлснийг гэрчлэх баримт бичгийн баталгаажуулсан хуулбар;

б/ажил олгогчийн тодорхойлолт;

в/зөвшөөрлийн гэрчилгээ.

## Дөрөв.Зөвшөөрлийг хүчингүй болгох

25.Эрүүл мэндийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тохиолдолд мөн зүйлд заасан хугацаагаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн дагуу зөвшөөрлийг Магадлан итгэмжлэх байгууллага хүчингүй болгоно.

26.Зөвшөөрлийн хугацаа дууссан бөгөөд сунгуулаагүй бол зөвшөөрөл хүчингүй болсонд тооцогдоно.

27.Зөвшөөрөл энэхүү журмын 25-д заасан нөхцөлөөр хүчингүй болсон бол хүчингүй болгосон хугацаа нь дууссаны дараа, 26-д заасан нөхцөлөөр хүчингүй болсон

бол хугацаа харгалзахгүйгээр уг мэргэжилтэн зөвшөөре шинээр авах хүсэлтээ Эрүүл мэндийн магадлан итгэмжлэ байгууллагад гаргаж болно.

**Тав.Зөвшөөрөл авсан эмнэлгийн мэргэжилтний бүртгэл, мэдээлэл**

28.Зөвшөөрөл авсан, сунгуулсан, зөвшөөрөл н хүчингүй болсон эмнэлгийн мэргэжилтний тухай мэдээл лийг Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллагы мэдээллийн санд бүртгэж, нийтэд тухай бүр мэдээлнэ.

29.Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллага н зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгохтой холбоо тойгоор эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо, мэргэж лийн хяналтын алба, хуулийн болон бусад байгууллага хувь хүмүүсээс ирүүлсэн албан ёсны мэдээллий бүртгэж, холбогдох лавлагаа өгнө.

Засгийн газрын 1998 оны 181 ду гээр тогтоолын 4 дүгээр хавсрал

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ ОЛГОХ, СУНГАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.Эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэ (цаашид "итгэмжлэл" гэх) олгох, сунгах, хүчингү болгох үйл ажиллагаа Эрүүл мэндийн тухай хууль энэхүү журам болон бусад хууль тогтоомжос зохицуулна.

2.Итгэмжлэл нь түүнд заасан шатлал, чиглэлий эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тухайн байгууллаг чанарын өндөр түвшинд үзүүлэх чадварыг төрөөс хүлээ зөвшөөрсний илэрхийлэл байна.

3.Итгэмжлэл нь уг байгууллагын өрсөлдөх чадвары нотолгоо, төрөөс санхүүгийн дэмжлэг авах баталгаа анагаах ухаан, сургалт, эрдэм шинжилгээний ажи эрхлэх итгэлцүүр болно.

**Хоёр.Итгэмжлэл олгох үйл ажиллагаа**

4.Итгэмжлэлийг эрүүл мэндийн байгууллагын үйлчи гээний чанар, барилга байгууламжийн нөхцөл, тоно

эхөөремжийн хүчин чадал, мэргэжлийн боловсон хүчний элтгэл, ур чадвар, ёс зүйн түвшин нь тухайн шатлал, иглэлийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эхнологи, стандартын шаардлагад нийцсэн эсэхийг эргэлзэн олгоно.

5.Итгэмжлэлийг мэргэжлийн үйл ажиллагаа явуулах усгай зөвшөөрөл авч 3-аас доошгүй жил тогтвортой үйл киллагаа явуулсан эрүүл мэндийн байгууллагад олгоно.

6.Итгэмжлэл авах хүсэлт гаргасан байгууллага нь нэ журмын 7-д заасны дагуу товлон зарласан угацаанаас 2 сарын өмнө материалаа бүрдүүлэн орон утгийн салбараар дамжуулан Магадлан итгэмжлэх айгууллагад өгнө.

7.Итгэмжлэл олгох үйл ажиллагааг тусгай хуваарийн агуу жил бүр явуулна.

8.Итгэмжлэл авах хүсэлт гаргасан байгууллага нь араахь материалыг бүрдүүлнэ:

а/итгэмжлэл авах тухай хүсэлт;

б/мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай эвшөөрлийн хуулбар;

в/магадлан итгэмжлэх байгууллагаас батлан гаргасан уулгын дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагаа, эхнологи, стандартын түвшинд өгсөн үнэлэлт;

г/мэргэжлийн хяналтын болон хэрэглэгчдийн эрх згийг хамгаалах байгууллагын санал.

9.Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллагын нижээч итгэмжлэл авахыг хүссэн байгууллагын үйл киллагаанд дараахь шалгуурыг баримтлан дүгнэлт ргана:

а/эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологи, тандартын мөрдөлт;

б/эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын үндсэн үүлэлт;

в/барилга байгууламжийн хүчин чадал, эрүүл ахуй, лдвар хамгааллын нөхцөл;

г/техникийн ба аюулгүй ажиллагааны шаардлага;

д/тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хүчин чадал, нар, ашиглалтын байдал;

е/мэргэжлийн боловсон хүчний бэлтгэл, ур чадвар, зүйн түвшин;

ж/байгууллагын бүтэц зохион байгуулалтын удирд-гын түвшин;

з/санхүүгийн үйл ажиллагааны чадавхи (аудитын йгууллагын үнэлгээ).

10.Итгэмжлэл олгох, эсэх асуудлыг Магадла итгэмжлэх байгууллага шинжээчийн санал, дүгнэлтий хүлээн авснаас хойш 2 долоо хоногийн дотор гаргана.

11.Итгэмжлэл олгосныг гэрчилж, Магадлан итгэмжлэ байгууллагаас гэрчилгээ болон алдаршуулах хая олгоно.

12.Итгэмжлэл авсан, итгэмжлэл нь хүчингүй болсо эрүүл мэндийн байгууллагыг Магадлан итгэмжлэ байгууллага бүртгэж, энэ тухай нийтэд зарлана.

13.Итгэмжлэл авахаар хүсэлт гаргасан байгууллага эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологи, стандарты шаардлага хангаагүй гэсэн үндэслэлээр итгэмжлэ олгоогүй бол 12 сарын дараа дахин хүсэлт гарга болно.

### Гурав.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын түвшинг дээшлүүлэх хөтөлбөр

14.Итгэмжлэл авсан байгууллага нь эрүүл мэндий тусламж, үйлчилгээний чанарын түвшинг дээшлүүлэ хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

15.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын түвши дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ тухайн бай гууллага Магадлан итгэмжлэх байгууллагатай гэрэ байгуулан ажиллана.

### Дөрөв. Итгэмжлэлийг сунгах

16.Итгэмжлэлийг 5 хүртэл жилийн хугацаатайгаа сунгана.

17.Итгэмжлэлийг сунгуулахыг хүссэн байгууллага дараах баримтыг бүрдүүлнэ:

а/итгэмжлэлийг сунгуулах тухай хүсэлт;

б/эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын түвши дээшлүүлэх гэрээний биелэлт;

в/мэргэжлийн хяналтын болон хэрэглэгчдийн эр ашгийг хамгаалах байгууллагын санал.

18.Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллага хэрэгтэй гэж үзвэл дээр дурдсанаас бусад холбогд материалыг шаардаж болно.

19.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын түвши дээшлүүлэх гэрээний биелэлт, мэргэжлийн хяналт болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллаг санал зэргийг үндэслэн итгэмжлэлийг сунгах, эсэхи

гадлан итгэмжлэх байгууллага 1 сарын дотор йдвэрлэнэ.

### Тав.Итгэмжлэлийг хүчингүй болгох

Дараахь нөхцөлд итгэмжлэлийг хүчингүй болгоно:
20.Итгэмжлэл авсан эрүүл мэндийн байгууллагын сламж, үйлчилгээний талаар үйлчлүүлэгчдээс гарсан мдол нь үндэслэлтэй болохыг эрх бүхий байгууллагаас гтоосон.
21.Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллагатай йгуулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нарын түвшинг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх рээг биелүүлээгүй.
22.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ явуулах хнологи, стандартыг зөрчсөнийг мэргэжлийн хяналтын банаас тогтоосон.
23.Итгэмжлэлийн хугацаа дуусcан.
24.Итгэмжлэл авсан эрүүл мэндийн байгууллага бүтэц хион байгуулалтын өөрчлөлтөд орсон.

